

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

ОРХОН АЙМГИЙН МУЗЕЙ								
Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Дара эх	09.05	1	Өн:13см, суурийн дм 5,5см,Жин 285гр	6101ОРМ0035 5	“Өндөр Занабазар”..... Ж.Чойнхор, С.Норовсамбуу нарын 1995 онд гаргасан ном зүйгээс уншиж судалсан.	Босоо Дара эх нь Энэтхэг, Балба улсад түгээмэл дэлгэрсэн байдаг байна.Монголд ихэнхдээ суугаа дара эхүүд дэлгэрсэн байдаг. Ийм төрлийн босоо байдалтай дара эх төдийлөн дэлгэрээгүй байдгаараа онцлогтой. Босоо байдалтай дара эхийг дүрслэхдээ ихэнхдээ Ногоон дара эх тэнгэрээс бууж байгаа мэт төсөөлөн дүрсэлдэг. Г.Занабазарын дэг сургуулийн хийц: Нэг хэвэнд цул цутгаж, алтаар шармалдсан. Бурхан дүрслэлийн урлагт бурхан бүтээх нарийн хэмжээ, тиг харьцаа, биеийн хөдөлгөөн, нүүр царай, нүдний харц, мутар гарын чагж, атрибут дүрслэлээр буддын гүн ухааны онол, үзэл бодлыг уран сайхны аргаар илэрхийлж чадсан. Духны чимэг, ээмэг зүүлт, бугуйвч, шагайвч, нимгэн торгомсог хувцасны материаллаг чанарыг маш нарийн урлаг төгс гаргаж өгчээ. Эмэгтэй хүний гоо сайхныг илэрхийлж алхаж байгаагаар дүрсэлж харуулсан дахин давтагдашгүй ховор хийц, урлалтай. Яг ийм тигийн дагуу төрх байдал нүд уруул, харцыг дүрсэлсэн учраас Г.Занабазарын дэг сургууль мөн гэж үзэж байгаа	Түдгэлзсэн

							тул үнэт зэрэглэлд бүртгүүлэх санал дэвшүүлж байна. Г.Занабазарын хүрэл цутгамалын “ Нэрэх” өвөрмөц аргыг нээж гаргаж ирсэныг судлаачид тогтоосон бөгөөд, Занабазарын бүтээлийг бүхэлд нь харахад хүний биеийн харьцаа хэмжээний тухай Данжуурт нарийвчлан зааж өгсөн байдаг	
НИЙТ 1 ДЭСИЙН 1 ШИРХЭГ								